

БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ЭТГЭЭДЭД ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭЖ БУЙ БАЙДАЛ

THE CURRENT CONDITION FOR CHARGING PEOPLE WHO HAVE COMMITTED PROPERTY THEFT WITH CRIMINAL LIABILITY

Б.ЭНХБОЛД

Хууль сахиулахын их сургуулийн Цагдаа судлалын төвийн эрхлэгч, хууль зүйн ухааны доктор, цагдаагийн хошууч

ENKHBOLD B.

(Ph.D. & Police Major) Head of the Police Studies Center, Law Enforcement University

Ц.САНЧИР

Дорнод аймгийн цагдаагийн газрын Халх гол сум дахь цагдаагийн хэсгийн дарга, магистрант, цагдаагийн хошууч

SANCHIR TS.

(M.L. STUDENT & POLICE MAJOR) Chief of the Khalkh Gol Soum Police Station, Dornod Aimag

Товч агуулга: Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд Монгол улсад бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг тулгамдсан асуудал болсоор байна. Энэхүү судалгааны ажлаар бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн шүүхээр шийдвэрлэж буй байдалд дүн шинжилгээ хийхийг зорьсон болно. Судалгааны ажил нь Цагдаагийн ерөнхий газар, Улсын дээд шүүхийн практик судлалын төв болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судалгааны тайланд тус тус үндэслэгдсэн болно. Судалгааны үр дүн Сүүлийн 5 жилд цагдаагийн байгууллагад жилд дунджаар 8900 бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг бүртгэгдэж үүнээс 1036 буюу 11.7 (%) нь шүүхээр шийдвэрлэгдсэн байна. Хулгайлах гэмт хэрэгт оногдуулж буй ялын төрөл хэмжээг авч үзвэл 80 орчим хувьд нь хорих, баривчлах зэрэг нийгмээс тусгаарлах ял оногдуулж байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулж буй ялын бодлого чангааг илтгэж байна.

Abstract: Theft offences have been becoming one of the serious problems in Mongolia for last two decades. Almost everybody has experienced to be theft victim. The main purpose of this study is to make analysis and conclusion on current state of sentencing for theft. Information resource was collected from National Police Agency, Research center at Supreme Court, and Judicial research, information, training institute at Judicial General Council. Last five year statistics show that averagely 8900 theft incidents reported in a year at police which is 1036 or 11.7 percent out of all crimes adjudicated. As for sentence type and

length, 80 percent of defendants were imposed imprisonment. It reveals that sentence policy has been very strict towards defendants.

Түлхүүр үгс: Хулгайлах, гэмт хэргийн бүрэлдэхүүн, ял, баривчлах ял, хорих ял.

Keywords: Theft trend, Corpus delicti, punishment, Incarceration, Imprisonment, adjudicated by court.

1. Удиртгал

Монгол улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 3-т “Иргэд хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх, шударгаар олж авах, эзэмших, захиран зарцуулах, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно”¹ гэж заасан нь бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн үндсэн зохицуулалт юм. Бусдын өмчлөх эрхийг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулж эрүүгийн хуулийн хамгаалалтад авсан бөгөөд хэн нэгэн этгээд иргэдийн өмчлөлийн эд зүйлийг хулгайлах замаар өөрийн эзэмшилд авсан бол Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байдаг.

Сүүлийн 1 жилийн судалгааны дүнгээс үзвэл бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг нь Монгол Улс дахь гэмт явдлын бүтцэд дангаараа 37.4 хувь шүүхээр шийдвэрлэж байгаа эрүүгийн хэргүүдийн, хувийг тус эзэлж байна. Энэ учир шалтгааны улмаас тодорхой төрлийн гэмт хэрэг, тэр дундаа бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагын асуудлыг сонгон судлах оролдлого хийлээ.

Монгол Улсад бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн талаар олон тооны
¹ NPA. (2011). Current conditions of crimes committed in Mongolia: 2006 -2010, Ulaanbaatar: National Police Agency of Mongolia



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ САХИУЛАХ
УНДЭСЛЭЛ

бүтээл, судалгаа шинжилгээний ажил хийгдсэн боловч бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх онол, шүүхийн практикийн талаар дагнасан судалгаа шинжилгээний ажил хараахан хийгдээгүй байна.

Энэхүү судалгааны ажлын зорилго нь бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт ял оногдуулж байдлыг судалж дүгнэлт хийхэд оршино. Энэ зорилгын хүрээнд бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлага- Онолын үндэслэл, Монгол Улс дахь хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал, хулгайлах гэмт хэрэгт ял оногдуулж буй байдал гэсэн 3 объектыг сонгон авсан болно. Судалгааны ажлын мэдээллийн эх сурвалжийг Цагдаагийн ерөнхий газар, Улсын дээд шүүхийн практик судалгааны төв, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судалгааны тайланд тус тус үндэслэсэн болно.

1. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлага-Онолын үндэслэл

Криминологийн сонгодог онолыг XVIII зууны үеийн соён гэгээрүүлэгч, философич Чезаре Бекариа (Итали) болон Жерми Бентам (Англи) нар үндэслэсэн бөгөөд тэд орчин үеийн гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны шинэтгэлд үнэтэй хувь нэмэр оруулсан хуульч, гүн ухаантан юм. Криминологийн сонгодог онолын үзэл баримтлал нь хүн бүр гэмт хэрэг үйлдэх боломжтой бөгөөд гэмт хэрэг үйлдэх, эс үйлдэх нь тэдний чөлөөт ухамсраас шалтгаална. Хүнийг гэмт хэрэг үйлдэхээс ухамсартайгаар татгалзуулах ухаалаг механизм нь үндэслэл бүхий хуулийн хориглолт байх ёстой, тэрхүү хориглолт нь эрүүгийн хуульд тусгасан ял хэлбэрээр илэрнэ гэсэн философи гаргалгааг дэвшүүлсэн. Хориглолт үндэслэлтэй байх нь ял шуурхай байх (Celerity), ял гарцаагүй байх (Certainty), ял тохирсон байх (severity) явдлаар хэмжигдэнэ. Тиймээс Эрүүгийн хуульд эдгээр ойлголтуудыг зарчим болгож хуульчилж өгөх ёстой гэсэн санал дэвшүүлсэн нь орчин үеийн эрүүгийн эрх зүйн сонгодог зарчим болж дэлхийн ихэнх улсын хуульд тусгалаа олсон байна.

Гэмт хэрэгт оногдуулах ял, түүний төрөл хэмжээг зөвхөн хуулиар тогтоох бөгөөд шударга ёсны зарчмын дагуу ямар ч шүүх өөрөө нийгмийн нэг хэсэг атлаа нийгмийн гишүүдэд зориулан ял тогтоож болохгүй.

Тиймээс нийтийн эрх ашиг сонирхолд халдсан үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох эрх нь зөвхөн хууль тогтоох субъектэд хадгалагдах ёстой бөгөөд ял нь хатуу, харгис, залхаан цээрлүүлэх шинжтэй байхаас татгалзаж гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэм буруугийн шинжид тохирсон сонголттой байх, харин шүүх хуульд зааснаас хатуу болон хуулиар тогтоогоогүй ял оногдуулах ёсгүй, түүнчлэн гэмт хэрэг үйлдсэн хүнийг шуурхай илрүүлж зохих ялыг шударгаар оногдуулах боломжийг цагдаагийн байгууллага хариуцах үүрэгтэй гэж үзсэн.

Энэ онолыг удирдлага болгон боловсруулан баталж 2002 оны 09 сарын 1-ээс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн Монгол Улсын эрүүгийн хуулийн тусгай ангийн "Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг" гэсэн 19 дүгээр бүлгийн 145 дугаар зүйлд "Бусдын эд хөрөнгийг хулгайлах" гэмт хэргийг хуульчилж, оногдуулах ялын төрөл хэмжээг нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг нь харгалзан 4 хэсэгт ялгаатай байдлаар хуульчилсан байна.

2. Монгол Улс дахь бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдлын тойм


Сүүлийн 20 гаруй жилийн судалгаанаас үзвэл бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг нь Монгол Улс дахь гэмт явдлын бүтцэд дангаараа 47.4 хувийг эзэлж, нийт үйлдэгдсэн хулгайлах гэмт хэргийн 53 хувь нь Улаанбаатар хотод, 47 орчим хувь нь хөдөө орон нутагт үйлдэгдсэн байна. Хулгайлах гэмт хэргийн улмаас иргэд аж ахуй нэгж байгууллагад учруулж буй хохирлын хэмжээ жилээс жилд нэмэгдэж байгаа шунахайн сэдэлтэй нийтлэг үйлдэгддэг гэмт хэрэг болоод байна.

Улсын хэмжээнд 1990-1994 оны хооронд энэ төрлийн гэмт хэргийг улсын хэмжээнд 36833 бүртгэж авснаас 15465 буюу 41 хувь нь тус хотод бүртгэгдэж жилийн дундаж 3093 гэмт хэрэг болж өссөн байна. Харин 1995-1999 оны хооронд хулгайлах гэмт хэрэг улсын хэмжээнд 61633 бүртгэгдсэнээс 26484 буюу 42,9 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдэж жилийн дундаж 5296,8 гэсэн үзүүлэлттэй байна. Бусдын эд хөрөнгө хулгайлах гэмт хэргийг 2001-2005 онд улсын хэмжээнд 42141 бүртгэж авснаас нийслэлд 21316 буюу 50.5 хувь нь ногдож байсан бол 2006-2010 онд улсын хэмжээнд 33346 бүртгэж үүнээс 16283 буюу 48 хувь нь нийслэлд тус тус ногдож байна.

Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдлыг бодитоор гаргаж дүгнэлт хийхэд гэмт хэргийн түвшинг бодитойгоор тодорхойлох шаардлагатай. Гэмт хэргийн түвшин гэдэг нь /level standart of criminality/ криминологид ихэвчлэн эрүүгийн хариуцлага хүлээлгэх насанд хүрсэн 100.000 хүн тутамд ноогдох тодорхой хугацааны туршид нэг нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн түвшинг тогтооход ашигладаг эрүүгийн хариуцлага хүлээлгэх насыг 14 насаар авч үзэн тодорхойлдог. Иймээс Монгол Улс дахь бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн түвшинг тодорхойлохын тулд эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрсэн 100.000 хүн тутамд ноогдох тухайн гэмт хэргийн түвшинг он дарааллаар авч үзье.

График 1-т 1990-2015 оны хооронд Монгол Улс дахь бусдын эд хөрөнгийн хулгайлах гэмт хэргийн чиг хандлагыг 100.000 хүн амд ногдох түвшингээр харуулсан байна. Судалгаанаас үзэхэд Монгол Улс дахь нийт гэмт хэрэг болон бусдын эд хөрөнгө хулгайлах гэмт хэргийн чиг хандлага, хөдөлгөөн ерөнхийдөө ижилхэн байгаа нь Монгол Улсын дахь гэмт хэргийн чиг хандлага хулгайлах гэмт хэргээс хамааралтай байгаа харуулж байна. 1990-1997 оны хооронд бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг улсын хэмжээнд тогтвортой өсч 100.000 хүн амд ноогдох дундаж түвшин 578 байсан бол 1998 оноос буурах хандлагатай болж 2003 онд дундаж түвшин 351 болжээ, харин 2004 оноос энэ үзүүлэлт өсөх хандлагатай хэлбэлзэж дундаж түвшин 274 болсон байна. Харин 2011-2015 оны хооронд бусдын эд хөрөнгө хулгайлах гэмт 30719 бүртгэгдсэн нь жилийн дундаж 7403, 100,000 хүн амд ногдох түвшин 251 гэсэн үзүүлэлттэй байна. 2015 оны хувьд 100,000 хүн амд ногдох хулгайлах гэмт хэргийн түвшин 299 байгаа нь сүүлийн 8 жилийн үзүүлэлтээс хамгийн өндөр үзүүлэлтэд тооцогдож, цаашид өсөх хандлагатай байна.

График 1. 100.000 хүн амд ногдох бусдын эд хөрөнгийн хулгайлах гэмт хэрэг 1990-2015



Эх сурвалж: ЦЕГ-ын мэдээлэл, дүн шинжилгээний алба

Дээрх судалгааны дүнгээс харахад Монгол Улс дахь гэмт хэргийн түвшин, хөдөлгөөн нь бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн түвшингээс хамааралтай байгаа харуулж байна. Монгол Улсад 1990-1997 оны хооронд бүх төрлийн гэмт хэрэг ялангуяа бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг огцом өссөн шилжилтийн үеийн нийгэм эдийн засгийн хямрал, хүн амын амьжиргааны түвшинд гарсан өөрчлөлт, хууль сахиулах байгууллагын хяналт суларсан зэрэг хүчин зүйлүүдтэй холбон тайлбарлаж болно. Гэмт хэргийн шалтгааныг нийгмийн стрессын онолын үүднээс тайлбарлавал хувь хүний хэрэгцээ түүндээ хүрэх боломжийн хооронд үүсэх зөрүүтэй байдал гэж тайлбарладаг. Шилжилтийн нийгэм түүнээс үүдэлтэй эдийн засгийн хямралын үед нийгмийн гишүүдийн орлого буурч өөрсдийн хэрэгцээгээ хангаж чадахгүйгээс шалтгаалан гэмт үйлдлийн замаар эд материалыг олж авах явдал түгээмэл гардаг (Мертон, 1975). Шунахайн сэдэлтэй өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг

ихэвчлэн ажилгүйдэл, ядуурал, орлогын тэгш бус байдал, нас, хүйс боловсролын түвшин, гэр бүлийн нөхцөл байдлаас ихээнхэн шалтгаалдаг (Buonanno, 2003). Энэ онолын үүднээс авч үзвэл 1990-1992 оны хороонд Монгол Улсад үнийн өсөлт 4 дахин нэмэгдэж, улсын хэмжээнд 69,000 өрх амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур, нийт иргэдийн 35,9 хувь нь ядуу болон нэн ядуу, ажилгүйдлийн түвшин 6,3 хувьтай болжээ. Нийт гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн 66,3 хувь нь ажилгүй, 71 орчим хувь нь ядуу ангилалд, 55,9 хувь нь 18-30 насны хүмүүс байжээ (Үндсэний статистикийн газар, 1997). 1998 оноос бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг буурсан шалтгаан Монгол Улсын эдийн засгийн өсөлт, иргэдийн амьжиргааны болон боловсрол, соёлын түвшин дээшилсэн нь гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаанд эерэгээр нөлөөлсөн гэж үзэж болно. Харин бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн чиг хандлага 2007 онд өссөн үүлэлттэй байсан бол 2011 он хүртэл буурч одоогийн чиг хандлага өсөх төлөвтэй байна. дээрх нөхцөл байдлаас харахад бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн чиг хандлага Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарч байгаа нь тогтоож байна. тухайлбал 2007 онд Монгол Улсын эдийн засгийн өсөлт буурч байхад энэ төрлийн гэмт хэрэг өсөх хандлагатай болж эдийн засаг сэргэсэн үед гэмт хэргийн түвшин буурч байна. 2011 оноос эхэлсэн дэлхийн нийтийн эдийн засгийн хямрал манай улсад нөлөөлж улмаар энэ төрлийн гэмт хэргийн хандлага өсөх хандлагатай болжээ.

3.Бусдын эд хөрөнгө хулгайлах гэмт хэрэгт ял оногдуулж буй байдал

3.1. Хулгайлах гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэгдсэн байдал

Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх нэг хэлбэр нь энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд улсын нэрийн өмнөөс оногдуулдаг ял юм. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан ялаас гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн хор аюулын хэр хэмжээ, түүний хувийн байдалд нь тохирсон ялыг сонгон хэрэглэсэн тохиолдолд ялын үр нөлөө сайн байдаг. Иймд шүүхээс бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт оногдуулсан ялын төрөл, хэмжээг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзлээ.

Хүснэгт 1-т үзүүлснээр Монгол Улсын хэмжээнд 2011-2015 оны хооронд анхан шатны шүүхээр хулгайлах гэмт хэрэг 6600 шийдвэрлэгдсэн нь нийт хэргийн 21.5(%) -ийг эзэлж байна. Шүүхээр шийдвэрлэгдэж буй хулгайлах хэргийн тоо 2012 оноос жил дараалан өсөж, 2015 онд хамгийн өндөр үзүүлэлттэй байсан нь өмнөх онтой харьцуулахад 82 хэрэг буюу 5.7 хувиар өссөн байна. Шийдвэрлэгдсэн хулгайлах гэмт хэргийг түүний бүрэлдэхүүний төрлөөр нь авч үзвэл нийт хулгайлах гэмт хэргийн 9.6% ердийн бүрэлдэхүүнтэй хулгайлах гэмт хэрэг /ЭХТА-ийн 145 дугаар зүйлийн 1 дэх хэсэг/, 87.3% хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй хулгайлах гэмт хэрэг / ЭХТА-ийн 145 дугаар зүйлийн 2, 3 дэх хэсэг/, онц хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй хулгайлах гэмт хэрэг / ЭХТА-ийн 145 дугаар зүйлийн 4 дэх хэсэг/ 2.9 хувийг эзэлж байна.

Хүснэгт 1. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэгдсэн байдлын судалгаа. (2011-2015)

Year	Хэрэг (145)	(%)	145.1	(%)	145.2	(%)	145.3	(%)	145.4	(%)
2011	1282	(100)	146	(10.5)	1064	(83.0)	55	(4.3)	27	(2.1)
2012	1281	(100)	147	(11.5)	1070	(83.5)	20	(1.6)	50	(3.9)
2013	1283	(100)	98	(7.6)	1111	(86.6)	33	(2.6)	41	(3.2)
2014	1336	(100)	129	(9.7)	1114	(83.4)	53	(4.0)	38	(2.9)
2015	1418	(100)	117	(8.3)	1234	(87.8)	16	(1.1)	37	(2.6)
Total	6600	(100)	637	(9.6)	5593	(84.7)	177	(2.6)	193	(2.9)



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ САХИУЛАХ
УНДСЭНЬ



Монгол Улсын шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим мэдээллийн сан Дээрх судалгаанаас үзвэл хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй хулгайлах гэмт хэрэг тухайлбал Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 2 дах хэсгээр шийдвэрлэгдсэн хэрэг жил дараалан өсөж байна. Энэ хэсэгт хулгайлах гэмт хэргийг түгээмэл үйлддэг арга, халдлагын зүйл, газар болох орон байр агуулах сав зэргийг тусгайлан заасан байдагтай холбоотой юм.(орон байр, агуулах саванд нэвтрэх, мал хулгайлах, бүлэглэн болон давтан үйлдэх гэх мэт). Түүнчлэн хулгайлах гэмт хэргийн улмаас учирсан хорлын хэмжээ нь энэ хэсэгт заасан хохиролтой ихэнх тохиолдолд тохирч байна.

4.2 Хулгайлах гэмт хэрэгт оногдуулж бу ялын төрөл, хэмжээ

Хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан ялын төрлийг хүснэгт-2 харуулсан байна. Сүүлийн 5 жилийн судалгаанаас үзвэл 10821 хүн хулгайлах гэмт хэрэгт ял шийтгүүлснээс 7010 буюу 64.7 % нь хорих, 2073 буюу 19.4% нь баривчлах, 397 буюу 3.6% нь албадан ажил хийлгэх, 685 буюу 6.26% нь торгох ялаар тус тус байна.

Хүснэгт 2. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан ялын төрөл (2011-2015)

Ялын төрөл Ял шийтгүүлэгчид										
	2011		2012		2013		2014		2015	
	2227 (100%)		2191 (100%)		2077 (100%)		2296 (100%)		2030 (100%)	
Торгох	142	(6.3)	151	(6.8)	122	(5.8)	149	(6.4)	121	(6.0)
Албадан ажил хийлгэх	71	(3.1)	94	(4.2)	88	(4.2)	73	(3.1)	71	(3.4)
Баривчлах	429	(19.2)	399	(18.2)	392	(18.8)	450	(19.5)	403	(19.5)
Хорих	1436	(64.4)	1393	(63.5)	1381	(66.4)	1501	(65.3)	1299	(64.0)
Хэрэгсэхгүй болгосон	45	(2.2)	153	(6.9)	94	(4.5)	123	(5.3)	121	(6.0)
Нэмэгдэл ял										
Эд хөрөнгө хураах ял	183	(8.2)	201	(9.1)	196	(9.4)	179	(7.7)	186	(9.1)

Монгол Улсын шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим мэдээллийн сан

Шүүхээс 2015 онд 121 хүнийг нийт 645 сая төгрөгийн торгох ялаар, 71 хүнийг 8400 цагийн албадан ажил хийлгэх ялаар, 103 хүнд нийт 12 сая төгрөгийн эд хөрөнгийг нэмэгдэл ялаар оногдуулжээ. Харин баривчлах ялаар 403 хүнийг шийтгэсэн нь дунджаар 2.6 сарын хугацаатай байна. 2011-2015 оны дунджаар хорих ял шийтгүүлсэн хугацааг авч үзвэл нийт хорих ял шийтгүүлэгчдийн 63(%) 2-3 жил, 20,1(%) нь 3-5 жил, 6.2(%) нь 5-8 жил, 4.1 хувь нь 8-10 жил, 6.6(%) нь 10-15 жил хүртэл хугацаагаар шийтгүүлсэн байна.

4.3. Хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан хорих ялын байдал

Хүснэгт 3-т хорих ял оногдуулсан шүүхийн тогтоолыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх судалгааг харуулсан байна. Сүүлийн 5 жилийн байдлаар хорих ялаар 7010 хүн шийтгүүлснээс 2853 буюу 40,7% хорих ялыг биечлэн эдлүүлсэн, үүнээс 93 хүн буюу 3.2% эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаас хөнгөрүүлж ял оноосон байна. Харин нийт хорих ял шийтгүүлэгчдийн 3740 буюу 49.3%-д оноосон ялыг 2.1 жил хүртэл хугацаагаар тэнссэн байна. Мөн нийт хорих ялаар шийтгүүлэгчдийн 440 буюу 6.2% насанд хүрээгүй этгээдэд оногдуулсан хорих ялыг хойшлуулсан /ЭХЕА-ийн 62/, 144 буюу 1,5% жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэгт оногдуулсан хорих /ЭХЕА-н 63/ тус тус хойшлуулсан байна.Түүнчлэн нийт 133 хүнд оногдуулсан хорих ялыг өршөөсөн байна.

Хүснэгт 3. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан хорих ялыг гүйцэтгэсэн байдал (2011-2015)

№		2011	2012	2013	2014	2015	
	Хорих ялаар бүгд: үүнээс	1436	(100%) 1393	(100%) 1381	(100%) 1501	(100%) 1299	(100%)
1	Хорих ялыг биечлэн эдлүүлсэн	598	(41.6) 564	(40.8) 555	(40.1) 617	(41.1) 519	(40.0)
	Тусгай ангид зааснаас доогуур ял оноосон (ЭХ-н 55-1-р зүйл)	24	(1.6) 13	(0.9) 16	(1.1) 21	(1.3) 19	(1.4)
2	Тэнссэн (61-р зүйл)	681	(47.4) 706	(50.6) 710	(51.1) 765	(51.0) 608	(46.8)
3	Ял хойшлуулсан (ЭХ- 62-р зүйл)	98	(6.8) 84	(6.0) 85	(6.1) 83	(5.5) 90	(6.9)
4	Ял хойшлуулсан (ЭХ-н 63 —р зүйл)	33	(2.2) 22	(1.5) 19	(1.3) 20	(1.3) 20	(1.5)
5	Өршөөсөн (ЭХ-н 77-р зүйл)	26	(1.8) 17	(1.2) 12	(0.8) 16	(1.0) 62	(4.7)

Дээрх судалгаанаас үзвэл хорих ялыг өндөр хувьтай оногдуулж байна. Энэ одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 1,2,3 дахь хэсэгт хорих ял оноохоор заасан бөгөөд ялангуяа 145 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт сонгох санкцгүйгээр хорих ялыг хуульчилсан байна. Мөн эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хорих ялын хугацааг 1-15 жил байхаар хуульчилсан байхад 145 дугаар зүйлийн 2 дэх хэсэгт хулгайлах гэмт хэрэгт оногдуулах хорих ялын доод хэмжээг 2 жил байхаар заасан нь хорих ялыг нэг жилийн хугацаагаар оногдуулах боломжийг хаасан зохицуулалт болжээ. Хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулахдаа эрүүгийн хуулийн 55-1 дүгээр зүйлд заасан “Эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаас хөнгөрүүлж хорих ял оноох” зохицуулалт бусад төрлийн гэмт хэрэгтэй харьцуулахад харьцангуй бага хэрэглэгдэж байна. Энэ нөхцөл байдал нь хуулийн зохицуулалттай холбоотой байх магадлалтай юм. Учир нь хууль тогтоогч 55-1 дүгээр зүйлд эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаас хөнгөрүүлж ял оногдуулахдаа дараах 3 үндсэн шаардлагыг хуульчилсан байна. 1) хорих ял оногдуулж болох гэмт хэрэг анх удаа үйлдсэн байх 2) гэмт хэргийн хохирлыг барагдуулсан байх 3) гэмт этгээдийн хувийн байдлыг харгалзах гэжээ. Дээрх 3 шаардлагаас гэмт хэргийн хохирлыг

нөхөн төлсөн байх гэсэн шаардлага ихэнх тохиолдолд хангагддаггүй байна. Сүүлийн 5 жилийн судалгааны дүнгээс үзвэл хулгайлах гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн 52,5 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй, 8,9 хувь нь согтуугаар, 49,2 хувь нь бүлэглэн үйлдсэн, 17,2 хувь нь урьд шийтгэгдэж байсан хүмүүс байна.

Дүгнэлт

1. Монгол Улсад үйлдэгдэж буй гэмт хэргийн бүтцэд бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг дангаараа 48 орчим хувийг эзэлж байна. Сүүлийн 5 жилийн судалгааны дүнгээс үзвэл цагдаагийн байгууллагад бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 30719 бүртгэгдэж үүнээс 6600 буюу 21.4 хувийг нь шүүхээр шийдвэрлэсэн байна.

2. Хулгайлах гэмт хэрэгт оногдуулж буй ялын төрөл хэмжээг авч үзвэл 80 орчим хувьд нь хорих, баривчлах зэрэг нийгмээс тусгаарлах ял оногдуулж байгаа нь хулгайлах гэмт хэрэгт оногдуулж буй ялын бодлого чанга байгааг илэрхийлэх юм. Оногдуулсан хорих ялын 41 хувийг биечлэн эдлүүлдэг бол 59 хувьд нь эрүүгийн хуульд заасан үндэслэлээр ялыг тэнсэх буюу хойшлуулж байна.

3. Хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээд бусдад учруулсан хохирлоо нөхөн төлдөггүй, давтан болон бүлэглэж гэмт хэрэг үйлдэх



МОНГОЛ УЛСЫН
ХҮҮЛЬ САХИУЛАХ
УНДГАД СУДАЛГААНЫ
УНДГАД СУДАЛГААНЫ
УНДГАД СУДАЛГААНЫ



нь түгээмэл байдаг тул эрүүгийн хуулийн 55-1 дэх хэсэгт заасан “эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаас хөнгөрүүлж хорих ял оногдуулах” гэсэн үндэслэлээр ялын доод хэмжээг бууруулсан тохиолдол цөөн байна.

4. Хулгайлах гэмт хэрэгт оногдуулж буй хорих ялын дундаж хугацаа 4.3 жил байгаа нь ялын бодлого чанга байгааг харуулж байна. Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 2 дах хэсэгт хорих ялын үндсэн хугацааг 1-15 жил байхаар хуульчилсан байхад 145 дугаар зүйлийн 2 дэх хэсэгт хулгайлах гэмт хэрэгт оногдуулах хорих ялын доод хэмжээг 2 жил байхаар заасан нь хорих ялыг нэг жилийн хугацаагаар оногдуулах боломжийг хаасан зохицуулалт болжээ.

Санал

Хулгайлах гэмт хэрэгт оногдуулах хорих ялын хугацааг аль болох багасгах, хорих ял оногдуулсан тохиолдолд ял тэнсэх болон хойшлуулах уян хатан зохицуулалтыг тусгах шаардлагатай байна. Тухайлбал гэмт хэрэг үйлдсэн хүн тухайн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлж, эсхүл гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол хорих ялыг хөнгөрүүлэх нөхцөл байдал болгон эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, ялын доод хэмжээг багасгаж хорих ялыг нэг жилээс эхлэн оногдуулдаг байх шаардлагатай.